



## СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 11 өдөр

Дугаар д/8

Улаанбаатар хот

### Гамшгийн үеийн үзүүлэх сургуулалтын тухай

Нийслэлийн засаг даргын 2014 оны 01-р сарын 13-ны өдрийн №А/11 тоот захирамж, БЗД-ийн Онцгой комиссын 2014 оны 22-ны өдрийн 01 тоот албан даалгаварыг үндэслэн ТУШААХ НЬ:

- Нэг. Нийслэлийн засаг даргын №А11 дүгээр захирамжаар БЗД-ийн нутаг дэвсгэрт Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2014 оны 03-р сард зохион байгуулахаар шийдвэрлэсэн тул байгууллагынхаа гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мэргэжлийн анги, шуурхай бүлгүүдийг томилон 2014 оны 02-р сарын 15-ны дотор дүүргийн онцгой байдлын хэлтсээр хянуулан батлуулахыг СТХНХЭ дэд захирал /О.Баатаржав/-д үүрэг болгосугай.
- Хоёр. Монгол улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн 7-р зүйлийн 7.3.3-т заасны дагуу гамшгаас хамгаалах сургалтын төлөвлөгөө гаргаж, сургалт явуулсан дүнгээ 2014 оны 02-р сарын 15-ны өдөр дүүргийн онцгой комисст хүргүүлэхийг Гамшгаас хамгаалах штабын нарийн бичгийн дарга /С.Ариунболд/-д үүрэг болгосугай.
- Гурав. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, сургалтын үр дүнг танилцуулахыг СТХНХЭ дэд захирал /О.Баатаржав/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ - 2